

Монгол улсын Туслах технологийн үндэсний үйлчилгээ

Ерөнхий тойм

Др. С. Дипак & Д. Тулгамаа

ТТ-ийн үндэсний үйлчилгээ

- Протез, Ортоз
- Алхуулагч, дугуйтай алхуулагч, таяг, суга таяг, тэргэнцэр гэх мэтийн хөдөлгөөний хэрэгслүүд
- Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах бүтээгдэхүүн
- Сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах бүтээгдэхүүн
- Ой санамж, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах бүтээгдэхүүн
- Харилцах бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах бүтээгдэхүүн
- Өөрийгөө арчлахад зориулсан туслах бүтээгдэхүүнүүд

ТТ-ийн үндэсний үйлчилгээний ТҮВШНҮҮД

- Үндэсний түвшин – ТТ-ийн үндэсний төв (ПОҮ), Хүүхдийн сэргээн засах төв болон бусад нарийн мэргэшлийн үйлчилгээнүүд
- Улаанбаатар хотын дүүргүүд дэх үйлчилгээ
- Аймгуудын үйлчилгээ – 6 аймагт баригдах Хөгжлийн Төвүүд

ТТ-ийн үндэсний үйлчилгээ

- **Туслах бүтээгдэхүүнийг олгох гурван тогтолцоо:**
 - Тодорхой үнийн дүн бүхий энгийн туслах бүтээгдэхүүнийг олгох төвлөрөлийг сааруулсан түвшин. Хамгийн ойр нийлүүлэгчээс авах боломжтой;
 - Тэргэнцэр, сонсголын аппарат, хиймэл мөч зэрэг 3 бүтээгдэхүүнийг авах нийлүүлэгчидтэй хамтын ажиллагааны гэрээ хийх (Framework agreement);
 - Зөвшөөрөгдсөн хувийн нийлүүлэгчдээс туслах бүтээгдэхүүнийг олгох (одоо үйлчилж байгаа тогтолцоо)

ТТ-ийн үндэсний зөвлөл

- **ТТ-ийн үндэсний зөвлөлийг яамдын төлөөлөл, эрдэмтэд, сэргээн засалтын мэргэжилтнүүд, ХБИБ-ын төлөөллийг оролцуулж байгуулах. ТТ-ийн үндэсний зөвлөл нь:**
 - Үндэсний нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний жагсаалтыг тогтмол хянаж, Засгийн газарт зөвлөмж өгнө
 - Туслах бүтээгдэхүүнийг худалдан авах явцыг хянаж, хамтын ажиллагааны гэрээ хийх, хувийн нийлүүлэгчдийг сонгох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох гэх мэт зөвлөмж өгнө
 - Хэрэглэгчдийн сэтгэл ханамж, туслах бүтээгдэхүүний ашигтай байдал, сэлбэг хэрэгслийн хэрэгцээ, засвар үйлчилгээ зэргийг хянана

ТТ-ийн үзүүлэнгийн өрөө

- ТТ-ийг олгоход шинээр нэмэх элемент нь ТТ-ийн үзүүлэнгийн өрөө – ТТ-ийн Үндэсний Төв болон 6 Хөгжлийн төвд.
- ТТ-ийн үзүүлэнгийн өрөөг Протез, ортоз, тэргэнцэрийн үйлчилгээнүүдтэй холбож өгнө.
- ТТ-ийн үзүүлэнгийн өрөөнд бүх төрлийн энгийн болон үндсэн туслах бүтээгдэхүүнүүдийг олгоно. Тухайлбал алхуулагчаас авахуулаад нүдний шил, мөн урьдчилан програмчилсан сонсголын аппарат гэх мэт.
- Энд зөвлөгөө өгч, туслах бүтээгдэхүүнийг зөв ашиглах, засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулж, илүү комплекс бүтээгдэхүүнүүдийг хаанаас хэрхэн авах талаар удирдамж, чиглэл өгнө.

Протез, ортозийн технологийг өөрчлөх

- Сүүлийн арваад жилд ПОҮ протезийг үйлдвэрлэхээс илүү бэлэн деталиудыг угсрах ажил руу аажмаар шилжиж байна. Одоогийн байдлаар дотооддоо бортого, гутал, зарим нэгэн ортозийг үйлдвэрлэж байна. Бортого үйлдвэрлэх шинэ технологийг нэвтрүүлэх шаардлага бий. Мөн ажилтнууд бүтээгдэхүүнийг сайн тааруулж, тохируулах чадварыг эзэмших хэрэгтэй байна.

Протез, ортозийн технологийг өөрчлөх

- Мөн Протез, ортозийн үйлчилгээнд хөлний дижитал сканнер, 3D сканнер гэх мэтийг ашиглаж үлдэц хэсгийн хэв авах дижитал технологийг нэвтрүүлэх шаардлагатай. Мөн үндэсний түвшний мэргэжилтнүүд аймагт байгаа мэргэжилтнүүдтэй харилцаж мэдээллээ солилцож байх нь чухал.

Илүү сайн туслах бүтээгдэхүүнийг авах

- НҮБ-ын хүүхдийн сан, CLASP, Exceed гэх мэт байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ хийх илүү сайн чанарын тэргэнцэр, сонсголын аппарат, доод мөчний протезийг боломжийн үнээр авах боломжтой болно. Одоогийн байдлаар тэргэнцэр, сонсголын аппаратыг зөвхөн хувийн компаниуд олгож байгаа. Шинэ загварын бүтээгдэхүүнийг ТТ-ийн Үндэсний Төв болон Хөгжлийн төвүүдээр дамжуулан авч болно. Мөн ХБИБ-ууд болон ТББ-уудаар дамжуулан авч болно.

Эрдэм шинжилгээ & Инновац

- Туслах бүтээгдэхүүнийг Компьютерийн тусламжтай загвар (CAD), Компьютержсэн тоон үйлдвэрлэл, 3D хэвлэл зэргээр шинэ технологи, шинэ материалаар үйлдвэрлэж туршиж үзэх хэрэгтэй. Эдгээр нь дотоодын үйлдвэрлэл, зарим нэг деталийг нийлүүлэх, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх зэргээр Туслах бүтээгдэхүүний үйлдвэрлэлд онцгой үүрэг гүйцэтгэж болох юм. Мөн шинэ технологиор хийсэн бүтээгдэхүүнүүдийг Монголын цаг уурын болон орчны нөхцөл байдалд аюулгүй, эдэлгээтэй эсэхийг туршиж үзэх хэрэгтэй. ТТ-ийн Үндэсний төвд ШУТИС-тай хамтран ажиллаж Эрдэм шинжилгээ, Инновацийг төв байгуулахыг санал болгож байна.

ТТ-ийн үйлчилгээний сургалт

- Орон нутагт сургалт зохион байгуулах, ажлын байран дээр сургах
- ДЭМБ-ын Нэн шаардлагатай туслах бүтээгдэхүүний мэргэжилтэн бэлтгэх сургалт
- ТТ-ийн тэтгэлэгт сургалт

Дүгнэлт

- Монгол улсын Туслах технологи олгох тогтолцоо нь боломжийн сайн байдаг. Одоог хүртэл ТТ-ийг олгохдоо жижигчилсэн байдаг ба тэргэнцэр, сонсголын аппарат, протез гэх мэт комплекс бүтээгдэхүүний хувьд бэрхшээлтэй байгаа. АХБ-ны төсөл ТТ-ийн нөхцөл байдлыг өөрчилж, бүтээгдэхүүн олголтыг сайжруулж, илүү алслагдмал амьдардаг хүмүүст үйлчилгээг хүргэхэд боломж олгоно. Технологийг өөрчилж, бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээ бий болгосноор үйлчилгээ сайжрах юм. Мөн шилжилтийн хугацаанд тулгарсан асуудлуудыг шийдэж, сайн үр дүнд хүрэх шаардлагатай.